



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 4/428

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.1, 23.11.5, 23.12, 23.13 дахь заалтууд, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2026 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/1016 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржээр арилжигдсан, Монгол Улсын Засгийн газраас гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 52 долоо хоногийн хугацаатай, 40,000 ширхэг, нийт 4.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1322 (ЗГХБ-Б-52-500) кодтой, хямдруулалттай өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, төлбөр төлөгдсөн тул "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлээс хассугай.

2. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдэгдлийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.

3. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-т, цахим хуудас болон арилжааны системд холбогдох өөрчлөлт хийхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МӨНХБАТ



1526030873

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН
БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ
№1322**

Хэнд: “Үнэт цаасны төвлөрсөн
хадгаламжийн төв” ХХК-д

Огноо: 2026/09/...

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас хадгаламжаас хасах тухай
Үндэслэл:	“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026.09.12-ны өдрийн 4/428 дугаартай тушаал
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Засгийн газрын үнэт цаас
Үнэт цаасны төрөл: /хямдруулалттай, купонтой/	Хямдруулалттай
Үнэт цаасны нэр:	ЗГХБ-Б-52-500
Үнэт цаасны код: /тоон код, ISIN/	1322, MNZGKHB13224
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус
Үнэт цаасны тоо: /ширхэг/	40,000 /дөчин мянга/
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100,000 /нэг зуун мянга/
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	4,000,000,000 /дөрвөн тэрбум/
Үнэт цаасны хугацаа: /долоо хоног, сар/	52 долоо хоног
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа: /давтамж/	Хугацааны эцэст
Үнэт цаас арилжигдсан өдөр	2025.09.17
Үнэт цаасны хугацаа дуусах огноо	2026.09.16

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ